**НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Ерөнхий боловсролын 23 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: НТАГ-2025/726/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2025 он | Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга Ч.Болд<br>Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn<br><br>Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга Х.Түвшинбаяр<br>Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn<br><br>Аудитын менежер Я.Алтанцэцэг<br>Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Н.Баттогоо<br>Утас: 325093 Цахим хаяг: battogoon@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.02.25 № 01/209

танай ______________-ны № _______________-т

НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 23 ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ш.ОЮУНСҮРЭН ТАНАА

## Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн ерөнхий боловсролын 23 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

## Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

## Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Нийслэлийн ерөнхий боловсролын гадаад хэлний төрөлжсөн сургалттай 23 дугаар сургууль нь Нийслэлийн Боловсролын газрын баталсан хөтөлбөрийн дагуу Орос, Япон, Англи, Солонгос, Хятад, Герман гэсэн 6 хэлийг 4 дүгээр ангиас төрөлжүүлэн хичээллүүлдэг байна.

Тус сургуулийн суралцагчид олон улсын түвшин тогтоох шалгалтыг 5 дугаар ангиасаа өгч, сургууль төгсөхдөө сурагчдын 40 гаруй хувь нь дээд түвшин хангаж, дотоод, гадаадын их дээд сургуульд тэтгэлгээр суралцаж байна.

## Аудитын гол асуудал

Багш, сурагчдын ажиллах суралцах орчныг бүрдүүлэх, олон улсын сургалтын аргуудыг нутагшуулах, цахим орчинд зөв зохистой ажиллуулах зэрэг олон нөхцөлийг бүрдүүлж 2024 онд бага ангийн 12 танхим, дунд, ахлах ангийн 4 танхимд 263.1 сая төгрөгийн сүүлийн үеийн ухаалаг самбар, сургуулийн 2 давхрын эзэмшлийн талбайг 260.0 сая төгрөгөөр иж бүрэн зассан байна.

0003716

C:\Users\zendmene.d\Desktop\2025\Word\Yvsan bichig\2025.02.25.EBS.23.docx

**Бусад асуудал**

Нийслэлийн ерөнхий боловсролын 23 дугаар сургуулийн 2024 оны гүйцэтгэлийн тайланг 5 агуулгын хүрээнд 33 зорилт, 76 арга хэмжээг төлөвлөн 97.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ЭРДЭНЭЖАРГАЛ

C:\Users\zendmene.d\Desktop\2025\Word\Yvsan bichig\2025.02.25.EBS.23.docx

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,160,373,615.40** | **1,541,008,326.40** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 730,343,232.68 | 1,008,065,196.02 |
| **312** | **Банканд байгаа бэлэн мөнгө** | 730,343,232.68 | 1,008,065,196.02 |
| **3121** | **Төгрөг** | 730,343,232.68 | 1,008,065,196.02 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 730,343,232.68 | 1,008,065,196.02 |
| **33** | **АВЛАГА** | 3,850,437.47 | 313,499.98 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 3,850,437.47 | 313,499.98 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 426,179,945.25 | 532,629,630.40 |
| **351** | **Түүхий эд материал** | 2,436,870.36 | 1,174,759.16 |
| 35130 | Эм боох материал | 2,436,870.36 | 1,174,759.16 |
| **354** | **Хангамжийн материал** | 423,743,074.89 | 531,454,871.24 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 7,360,660.00 | 4,104,630.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 31,372,482.80 | 26,288,951.80 |
| 35450 | Барилгын засварын материал | - | 2,937,750.00 |
| 35460 | Хүнсний материал | - | 1,593,194.15 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 385,009,932.09 | 496,530,345.29 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **4,398,440,331.03** | **4,728,706,110.60** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 4,398,440,331.03 | 4,728,706,110.60 |
| **392** | **Биет хөрөнгө** | 4,114,766,731.03 | 4,419,973,510.60 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,593,475,706.20 | 3,464,420,146.64 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (612,543,425.20) | (685,088,246.32) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 1,590,396,436.27 | 2,171,074,454.15 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (930,168,815.38) | (996,776,722.20) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 839,552,192.95 | 877,550,467.15 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (390,496,019.20) | (435,757,244.21) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 13,000,000.00 | 13,000,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (13,000,000.00) | (13,000,000.00) |
| 39217 | Ном | 24,550,655.39 | 24,550,655.39 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 283,673,600.00 | 308,732,600.00 |
| 39301 | Программ хангамж | 25,595,000.00 | 51,635,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (24,275,000.00) | (25,256,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 282,815,600.00 | 282,815,600.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (462,000.00) | (462,000.00) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **5,558,813,946.43** | **6,269,714,437.00** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,907,910.00** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 1,907,910.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| **413** | **Өглөг** | 1,907,910.00 | - |
| **4136** | **Бусад өглөг** | 1,907,910.00 | - |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 1,907,910.00 | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **5,556,906,036.43** | **6,269,714,437.00** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 5,556,906,036.43 | 6,269,714,437.00 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,398,899,371.76 | 1,398,899,371.76 |
| 51101 | Өмч:- төрийн | 1,398,899,371.76 | 1,398,899,371.76 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,732,969,112.12 | 3,558,714,901.60 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,732,969,112.12 | 2,845,906,501.03 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 712,808,400.57 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,425,037,552.55 | 1,312,100,163.64 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **5,558,813,946.43** | **6,269,714,437.00** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **6,545,152,306.22** | **7,287,518,418.90** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,287,847,182.53** | **1,534,074,781.48** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,287,847,182.53 | 1,534,074,781.48 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 1,287,847,182.53 | 1,534,074,781.48 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,031,459,466.00 | 1,058,964,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 256,387,716.53 | 475,110,781.48 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **5,257,305,123.69** | **5,753,443,637.42** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 5,091,564,200.00 | 5,600,875,800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 5,091,564,200.00 | 5,600,875,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 165,740,923.69 | 152,567,837.42 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 165,740,923.69 | 152,567,837.42 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **5,584,287,058.29** | **6,491,718,602.45** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,584,287,058.29** | **6,491,718,602.45** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 5,212,160,858.29 | 6,129,038,716.60 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 3,725,795,078.99 | 4,393,061,843.55 |
| 210101 | Үндсэн цалин | 2,271,787,522.56 | 3,049,605,046.76 |
| 210102 | Нэмэгдэл | 1,307,706,838.19 | 1,012,026,522.06 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 15,803,000.00 | 62,069,112.10 |
| 210104 | Урамшуулал | 130,497,718.24 | 269,361,162.63 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 477,214,062.88 | 541,515,971.89 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 323,487,028.38 | 370,143,321.69 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 36,540,225.21 | 43,940,789.81 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 32,643,951.97 | 21,779,756.77 |

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 9,323,267.22 | 21,116,672.34 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 75,219,590.10 | 84,535,431.28 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 130,486,923.69 | 148,567,837.42 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 49,868,930.06 | 54,323,413.08 |
| 210302 | Түлш, халаалт | 52,578,115.83 | 50,944,089.71 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 28,039,877.80 | 43,300,334.63 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 94,852,309.68 | 167,610,458.80 |
| 210401 | Бичиг хэрэг | 43,860,124.00 | 73,154,267.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 50,992,185.68 | 51,079,966.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 43,376,225.80 |
| **2105** | **Нормативд зардал** | 755,511.42 | 2,173,806.20 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 755,511.42 | 2,173,806.20 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 253,391,176.00 | 242,012,673.00 |
| 210604 | Урсгал засвар | 253,391,176.00 | 242,012,673.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 47,619,400.00 | 90,177,629.71 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 16,918,400.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 30,701,000.00 | 90,177,629.71 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 482,046,395.63 | 543,918,496.03 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 80,020,865.00 | 85,853,905.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 402,025,530.63 | 458,064,591.03 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 372,126,200.00 | 362,679,885.85 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 372,126,200.00 | 362,679,885.85 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 256,695,000.00 | 245,371,485.85 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 115,431,200.00 | 117,308,400.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **960,865,247.93** | **795,799,816.45** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 82,991,415.88 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 82,991,415.88 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | (82,991,415.88) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **960,865,247.93** | **712,808,400.57** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **6,369,733,795.69** | **6,865,897,829.42** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,112,428,672.00** | **1,112,454,192.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,112,428,672.00 | 1,112,454,192.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,112,428,672.00 | 1,112,454,192.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,031,459,466.00 | 1,058,964,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 80,969,206.00 | 53,490,192.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **5,257,305,123.69** | **5,753,443,637.42** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 5,091,564,200.00 | 5,600,875,800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 5,091,564,200.00 | 5,600,875,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 165,740,923.69 | 152,567,837.42 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 165,740,923.69 | 152,567,837.42 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **5,699,484,370.03** | **6,060,261,566.08** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **5,699,484,370.03** | **6,060,261,566.08** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **5,327,358,170.03** | **5,695,988,486.08** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 3,727,935,516.46 | 4,391,242,106.06 |
| 210101 | Үндсэн цалин | 2,273,927,960.03 | 3,047,785,309.27 |
| 210102 | Нэмэгдэл | 1,307,706,838.19 | 1,012,026,522.06 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 15,803,000.00 | 62,069,112.10 |
| 210104 | Урамшуулал | 130,497,718.24 | 269,361,162.63 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 477,016,152.88 | 541,706,681.89 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 323,341,678.38 | 370,334,031.69 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 36,526,545.21 | 43,940,789.81 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 32,626,851.97 | 21,779,756.77 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 9,321,287.22 | 21,116,672.34 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 75,199,790.10 | 84,535,431.28 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 130,486,923.69 | 148,567,837.42 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 49,868,930.06 | 54,323,413.08 |
| 210302 | Түлш, халаалт | 52,578,115.83 | 50,944,089.71 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 28,039,877.80 | 43,300,334.63 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 26,386,690.00 | 18,486,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 26,386,690.00 | 18,486,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 513,029,426.00 | 290,439,079.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 123,712,900.00 | 14,885,400.00 |
| 210602 | Тавилга | 123,638,000.00 | 15,300,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 265,678,526.00 | 260,253,679.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 48,939,400.00 | 90,177,629.71 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 16,918,400.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 32,021,000.00 | 90,177,629.71 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 403,564,061.00 | 215,368,652.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 341,638,677.00 | 154,947,655.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 61,925,384.00 | 60,420,997.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **372,126,200.00** | **364,273,080.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 372,126,200.00 | 364,273,080.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 256,695,000.00 | 246,964,680.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 115,431,200.00 | 117,308,400.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **670,249,425.66** | **805,636,263.34** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **-** | **527,914,300.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **527,914,300.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 527,914,300.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | 527,914,300.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(527,914,300.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 670,249,425.66 | 277,721,963.34 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 60,093,807.02 | 730,343,232.68 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 730,343,232.68 | 1,008,065,196.02 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 1,398,899,371.76 | 1,425,037,552.55 | 2,732,969,112.12 | 5,556,906,036.43 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,398,899,371.76** | **1,425,037,552.55** | **2,732,969,112.12** | 5,556,906,036.43 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | - | - |
| C08 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,398,899,371.76** | **1,425,037,552.55** | **2,732,969,112.12** | **5,556,906,036.43** |
| D01 | **2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,398,899,371.76** | **1,425,037,552.55** | **2,732,969,112.12** | **5,556,906,036.43** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 112,937,388.91 | 112,937,388.91 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,398,899,371.76** | **1,425,037,552.55** | **2,845,906,501.03** | **5,669,843,425.34** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт,бууралт | - | (112,937,388.91) | - | (112,937,388.91) |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 712,808,400.57 | 712,808,400.57 |
| D09 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,398,899,371.76** | **1,312,100,163.64** | **3,558,714,901.60** | **6,269,714,437.00** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 7,598,615,537.4 | 6,588,175,866.1 | 1,010,439,671.3 | 86.7 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 7,598,615,537.4 | 6,588,175,866.1 | 1,010,439,671.3 | 86.7 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 7,213,039,637.4 | 6,223,902,786.1 | 989,136,851.3 | 86.3 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 5,074,679,900.0 | 4,391,242,106.1 | 683,437,793.9 | 86.5 |
| 210101 | Үндсэн цалин | 3,630,030,100.0 | 3,047,785,309.3 | 582,244,790.7 | 84.0 |
| 210102 | Нэмэгдэл | 1,249,162,500.0 | 1,074,095,634.2 | 175,066,865.8 | 86.0 |
| 210104 | Урамшуулал | 195,487,300.0 | 269,361,162.6 | (73,873,862.6) | 137.8 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 634,334,900.0 | 541,706,681.9 | 92,628,218.1 | 85.4 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 431,347,800.0 | 370,334,031.69 | 61,013,768.3 | 85.9 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 50,746,800.0 | 43,940,789.81 | 6,806,010.2 | 86.6 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 25,373,400.0 | 21,779,756.77 | 3,593,643.2 | 85.8 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 25,373,400.0 | 21,116,672.3 | 4,256,727.7 | 83.2 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 101,493,500.0 | 84,535,431.3 | 16,958,068.7 | 83.3 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 148,567,837.42 | 148,567,837.4 | - | 100.0 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 54,323,413.1 | 54,323,413.1 | - | 100.0 |
| 210302 | Түлш, халаалт | 50,944,089.7 | 50,944,089.7 | - | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 43,300,334.6 | 43,300,334.6 | - | 100.0 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 42,610,000.0 | 42,174,500.0 | 435,500.0 | 99.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 42,610,000.0 | 42,174,500.0 | 435,500.0 | 99.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 663,143,600.0 | 583,722,579.0 | 79,421,021.0 | 88.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 319,940,700.0 | 281,138,900.0 | 38,801,800.0 | 87.9 |
| 210602 | Тавилга | 86,602,900.0 | 42,330,000.0 | 44,272,900.0 | 48.9 |
| 210604 | Урсгал засвар | 256,600,000.0 | 260,253,679.0 | (3,653,679.0) | 101.4 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 136,892,800.0 | 90,177,629.7 | 46,715,170.3 | 65.9 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 136,892,800.0 | 90,177,629.7 | 46,715,170.3 | 65.9 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 512,810,600.0 | 426,311,452.0 | 86,499,148.0 | 83.1 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 451,328,300.0 | 365,890,455.0 | 85,437,845.0 | 81.1 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 61,482,300.0 | 60,420,997.0 | 1,061,303.0 | 98.3 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 385,575,900.0 | 364,273,080.0 | 21,302,820.0 | 94.5 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 385,575,900.0 | 364,273,080.0 | 21,302,820.0 | 94.5 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 268,267,200.0 | 246,964,680.0 | 21,302,520.0 | 92.1 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 117,308,700.0 | 117,308,400.0 | 300.0 | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 6,872,362,337.4 | 6,865,897,829.4 | 6,464,508.0 | 99.9 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 5,600,875,800.0 | 5,600,875,800.0 | - | 100.0 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 5,600,875,800.0 | 5,600,875,800.0 | - | 100.0 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 152,567,837.4 | 152,567,837.4 | - | 100.0 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 152,567,837.4 | 152,567,837.4 | - | 100.0 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 1,118,918,700.0 | 1,112,454,192.0 | 6,464,508.0 | 99.4 |
| 120041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,058,774,000.0 | 1,058,964,000.0 | (190,000.0) | 100.0 |
| 120042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 60,144,700.0 | 53,490,192.0 | 6,654,508.0 | 88.9 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 192 | 154 | 38 | 80.2 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 160 | 125 | 35 | 78.1 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 31 | 28 | 3 | 90.3 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 370,776.2 мянган төгрөгийн 3 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 83,463.5 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 5,529.1 зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг давтан гаргахгүй байх 77,934.4 мянган төгрөгийн 2 зөвлөмж өглөө.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 83,463.5 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 300.8 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

# 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

## Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | | Үүнээс Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Өмчийн өөрчлөлтийн тайланд дахин үнэлгээний бууралтыг дутуу илэрхийлсэн. | 1 | 112,937.4 | - | - | 1 | 112,937.4 | 1 | 112,937.4 | - | - | - | - |
| 2 | Акталсан хөрөнгийн гарзыг үр дүнгийн тайланд дутуу илэрхийлсэн. | 1 | 82,991.4 | - | - | 1 | 82,991.4 | 1 | 82,991.4 | - | - | - | - |
| 3 | Үндсэн дэлгэрэнгүй бүртгэлд дахин үнэлгээний хасалтыг дутуу илэрхийлсэн. | 1 | 174,847.4 | - | - | 1 | 174,847.4 | 1 | 174,847.4 | - | - | - | - |
| | **Дүн** | **3** | **370,776.2** | **-** | **-** | **3** | **370,776.2** | **3** | **370,776.2** | **-** | **-** | **-** | **-** |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Зөрчлийн товч утга | **Нийт зөрчил** | | **Үүнээс: Төлбөрийн акт** | | **Албан шаардлага** | | **Зөвлөмж** | | **Хариуцлага тооцуулах албан шаардлага** | | **Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал** | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Албан тушаалтны тоо** | **Тоо** | **Дүн** |
| 1 | Сургалтын төлбөрийн орлогыг анги тус бүрээр тулгахад орлогыг дутуу авсан, тооцооны дансаар дамжуулж авлага, өглөгөөр бүртгээгүй байна. | 1 | 5,126.0 | 1 | 5,126.0 | - | - | - | - | - | - | - | - |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2 | Балансын шагнал урамшууллыг 300 хувь бодож 4,413.0 мянган төгрөг олгохдоо цалингийн дэлгэрэнгүй бүртгэлийн нэмэгдлийн 5 төрлийн ангиллаар илэрхийлсэн, нотлох баримтгүй 403.1 мянган төгрөгийн цалин олгосон. | 1 | 403.1 | 1 | 403.1 | - | - | - | - | - | - | - | - |
| 3 | Тайлант онд 12 ширхэг 26,600.0 мянган төгрөгийн ангиудын хаалга сольсныг үндсэн хөрөнгөнд хаалгыг орлогоор бүртгэн авч, шинээр авсан 39,004.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг эд хөрөнгийн ашиглалтын картыг хүн тус бүрээр шинэчилж, хөтөлж бүрэн баталгаажуулаагүй байна. | 1 | 65,004.4 | - | - | - | - | 1 | 65,004.4 | - | - | - | - |
| 4 | Хүүхдийн хоолны ирцийн бүртгэлийг анги удирдсан багш нар, сургалтын менежер зэргээрээ баталгаажуулаагүй, бүрэн нотлох баримтгүй зардал гаргаж тайлагнасан. | 1 | 12,930.0 | - | - | - | - | 1 | 12,930.0 | - | - | - | - |
| | **Дүн** | **4** | **83,463.5** | **2** | **5,529.1** | **-** | **-** | **2** | **77,934.4** | **-** | **-** | **-** | **-** |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| д/д | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | **Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| 1 | Тайлант онд цахим дэлгүүрээс бичиг хэрэг, аж ахуйн материалын худалдан авалт хийгээгүй байна. | 1 | 65,456.0 | | | | | 1 | 65,456.0 |
| 2 | Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гэрээ болон гүйцэтгэлийн тайланг tender.gov.mn болон шилэн дансны системд ил тодоор мэдээлээгүй байна. | 1 | - | | | | | 1 | - |
| | **Дүн** | **2** | **65,456.0** | | | | | **2** | **65,456.0** |

## Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Туувэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалт тай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | 1 | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | **1** | **1** | | | **1** | | | |

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# АКТ

2025 оны 02 дугаар сарын 28 № 29/А0260171 Улаанбаатар хот

НТАГ-2025/726/НА-СТА-ТШ3

## Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн ерөнхий боловсролын 23 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Анхан шатны нотлох баримтгүй 403,100.00 (дөрөв зуун гурван мянган нэг зуун) төгрөгийн цалин олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "*анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.3.8. "*Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн*" заалтад заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1.Анхан шатны нотлох баримтгүй олгосон 403,100.00 (дөрөв зуун гурван мянган нэг зуун) төгрөгийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын төрийн сан банкин дахь НТАГ.хүү орлогын 100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн ерөнхий боловсролын 23 дугаар сургуулийн захирал Ш.Оюунсүрэн, ахлах нягтлан бодогч О.Оюунжаргал нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН**[1]**:**

АХЛАХ АУДИТОР Н.БАТТОГООО

ХЯНАСАН:

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР Я.АЛТАНЦЭЦЭГ

1117145633
УХА0612 9077278

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

02051220

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АКТ

2025 оны 05 дугаар сарын 25 № 30/A0260171 Улаанбаатар хот

НТАГ-2025/726/НА-СТА-ТШЗ

## Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн ерөнхий боловсролын 23 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сургалтын төлбөрийн орлогыг 5,126,000.00 (таван сая нэг зуун хорин зургаан мянган) төгрөгөөр дутуу тооцсон, тооцооны дансаар дамжуулж авлага, өглөгөөр бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д "*үнэн зөв байх*", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*" гэж заасныг зөрчсөн байна.

*Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5." бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" заалтад заасныг үндэслэн ТОГТООХ нь:*

1.Сургалтын төлбөрийн орлого дутуу тооцсон 5,126,000.00 (таван сая нэг зуун хорин зургаан мянган) төгрөгийг Нийслэл дэх Төрийн аудитын газрын төрийн сан банкин дахь НТАГ.хүү орлогын 100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;

2.Актын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн ерөнхий боловсролын 23 дугаар сургуулийн захирал Ш.Оюунсүрэн, ахлах нягтлан бодогч О.Оюунжаргал нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН[1]:**

АХЛАХ АУДИТОР Н.БАТТОГОО

ХЯНАСАН:

САНХҮҮ,НИЙЦЛИЙН АУДИТЫН ХЭЛТСИЙН АУДИТЫН МЕНЕЖЕР Я.АЛТАНЦЭЦЭГ

[1] Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

02051?22